



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А991

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг дэмжих, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хавсралтад нэр дурдагдсан сууц өмчлөгчдийн холбоодын харьяалах 1 дүгээр хорооны 2, 3 дугаар байр, 2 дугаар хорооны 14 дүгээр байрны дээврийн засварын ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулсугай.

2. Төсвийг хавсралтаар баталж, засварын ажилд шаардагдах 4,155,000 (Дөрвөн сая нэг зуун тавин таван мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг хангах ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, дууссанаас хойш 10 хоногийн дотор үр дүнг эргэн танилцуулж, санхүүгийн тайланг ирүүлэхийг Хангайн өргөө сууц өмчлөгчдийн холбоо- (Д.Бужигдай)-нд, Их хангай сууц өмчлөгчдийн холбоо (З.Нармандах)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


1123200256

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 4 сарын 21-ны өдрийн 119/21 дугаар
захирамжийн хавсралт

1 ДҮГЭЭР ХОРООНЫ ХАНГАЙН ӨРГӨӨ СӨХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ	Хянасан
1	Цемент	ш	10	25,000	250,000	
2	Праймер /1 сав-18 литр/	лааз	5	65,000	325,000	
3	Чулуутай хар цаас Техноникель	Бо	15	75,000	1,125,000	
4	Чулуугүй хар цаас BLG Техноникель	Бо	15	67,000	1,005,000	
5	Тээврийн зардлын хөлс	км	200	-	400,000	
6	3 дугаар байрны дээврийн агааржуулалт, салхивчийн хоолойн өрлөгийг хэсэгчилж шинэчилж засварлах өрлөгийн ажил	М ³	1000	450	450,000	
7	Шингэнэ шил	л	10	8000	80,000	
Нийт үнэ:					3,635,000	

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 9 сарын 21-ны өдрийн 1001 дугаар
захирамжийн хавсралт



2 ДУГААР ХОРООНЫ ИХ ХАНГАЙ СӨХ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд үнэ	Хянасан
1	Чулуутай хар цаас	Бо	3	75,000	225,000	
2	Мастик	Лааз	1	110,000	110,000	
3	Газ /баллон/	ш	1	-	80,000	
4	Праймер /1 сав 18 литр/	Лааз	1	65,000	65,000	
5	Тээврийн зардлын хөлс	Км	200	-	40,000	
Нийт үнэ:					520,000	